

ЯПОН, БНСУ-ЫН АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ БОДЛОГЫГ ХАРЬЦУУЛАХ НЬ

Баяраагийн Нарантунгалааг, доктор (*PhD*), дэд профессор, МУИС-ШУС-ийн Эдийн засгийн тэнхим

Хураангуй

Япон, БНСУ-ын засгийн газраас хүн амын насжилт, ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтэнд ихээхэн ач холбогдол өгч, төрийн бодлогоор дэмжин зохицуулж байна. Энэ орнуудын засгийн газраас ахмад настанг хөдөлмөр эрхлүүлэх талаарх аж ахуйн нэгжийн үүргийг хуулиар баталгаажуулсан цогц бодлогуудыг боловсруулж, боловсронгуй болгосоор байна. Япон, БНСУ нь ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд тэтгэврийн насыг сунгах, тэтгэвэрт гарах насанд зохицуулалт хийх байдлаар бодлого хэрэгжүүлж байна. Мөн эдгээр орнууд өөрсдийн нийгэм, эдийн засгийн хөгжилд тохирох ахмад настнуудын ажил эрхлэлтийн бодлогыг боловсруулахдаа энэ талаарх судалгаа, тайланд ихээхэн ач холбогдол өгч байна.

Япон, Солонгост ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг засгийн газрын хөтөлбөр болгон хэрэгжүүлсэнээр ахмад хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн тэтгэврийн дарамтыг бууруулж, эдийн засгийн тогтвортой ёсөлтийг хангах ажиллах хүчиний нөөцийг бий болгож чаджээ.

Япон, БНСУ-ын хувьд засгийн газар, нийгэм, ард иргэд болон хувь хүмүүс нь хүн амын насжилт, мөн ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийн талаар гүнзгий ойлголттой болж, өмнөхөөсөө илүү идэвхтэй байдлаар хүлээн авч, ахмад настнуудын ажил эрхлэлтэнд зэрэгзээр хандах болж, хүн амын насжилт, ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдэх тал дээр нилээд ололттой байгаа юм. Иймд энэ 2 орны авч хэрэгжүүлж буй бодлогыг судлахыг зорилоо.

Түлхүүр үс: Япон, БНСУ, хүн амын насжилт, ахмад настны хөдөлмөр эрхлэлт

Abstract

The impact of population aging on our lives has been increasing in importance. In countries that have high levels of aging problems, the population aging is shown itself in the forms of scarcity of labor force and older labor force. Moreover, in those societies, the social pension funds eventually become unsustainable. Therefore, it is of significant importance and beneficial for us that we study how other countries are addressing their population aging problems.

Japan and the Republic of South Korea are among the countries that have been experiencing fast population aging problems. As a result, both countries pay especial attention to their populations' aging and the employment of their elderly labor forces. They try to regulate their problems with government policies. For instance, in both countries, comprehensive government policies keep being initiated and implemented and the employment of elderly labor force has been already made a part of employment obligations of corporations in the Corporate Employment Laws and retirement ages have gone up in support of elderly employment. In addition, the governments place significant focus on academic researches and studies conducted in the fields and take decisions based on those researches and studies when they design and launch any program and policy targeting aging problems.

Due to the successful implementation of the employment of the elderly labor force as government programs, there is now an elderly working class in Japan and the Republic of South Korea that helps reduce pressures on the public pension funds and also helps create sustainable economic growth. And both countries have reached an advanced degree in terms of the awareness and understanding, of population aging problems and the employment of elderly labor force at all levels of society and hence, the employment of the elderly has begun to be perceived as a positive incident and supported widely. Today, Japan and the Republic of South Korea have both advanced in their endeavor of solving the employment of their elderly population.

This study looks at the present state and the future trend, of population aging in Japan and the Republic of South Korea, the causes and the effects, of population aging on the employment of the elderly, in the countries, and then analyzes and compares the individual government policies addressing the employment of the elderly.

Key words: Japan, Korea, population aging, employment policy for elderly

1. УДИРТГАЛ

Хүн төрөлхтөний амьдралд хүн амын насжилт улам бүр чухал нөлөө үзүүлж байна. Насжилтын түвшин өндөр хурдтай байгаа орнуудын хувьд хүн амын насжилт нь ажиллах хүчний хомсдол болон ажиллах хүчний насжилтаар илэрдэг. Үүний зэрэгцээ хүн амын насжилт өндөр хурдтай байгаа нийгэмд тэтгэврийн ачаалал нэмэгддэг. Ахмад настны хөдөлмөр эрхлэлт нь ажиллах хүчний хомсдлыг бууруулах, тэтгэврийн ачааллыг бууруулах чухал арга зам юм.

Дэлхийн Банкаас гаргаж буй “Live Long and Prosper: Aging in east Asia and Pacific” тайланда дурдсанаар дэлхийн хүн амын 36 хувь эсвэл 211 сая хүн 65 ба түүнээс дээш настай иргэд Зүүн Азийн бус нутагт амьдарч байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулбал хамгийн өндөр үзүүлэлт ажээ. 2040 он гэхэд насжиж байгаа хүн амын өсөлтийн улмаас Өмнөд Солонгост хөдөлмөрийн насны хүн амын тоо 15 хувь, Хятад, Тайланд, Японд 10 хувь буурах магадлалтай байна. Мөн Хятад Улс дангаараа 90 сая ажилтнаа цэвэр алдана гэсэн үг хэмээжээ².

Насжилтын өсөлтийн хурд улс орон бүрт харилцан адилгүй байна. Хөгжингүй орнуудад тухайлбал Япон, Сингапур, Өмнөд Солонгост нийт хүн амын 14 ба түүнээс дээш хувь нь 65-аас дээш насны настангууд бол Хятад, Тайланд, Вьетнам зэрэг дунд орлоготой хөгжих буй улс орнуудад ч мөн хүн амын насжилт хэдийнээ өссөн төдийгүй насжилтийг хэрхэн зохицуулж удирдах талаар хамгийн тулгамдсан асуудалтай улс орнууд болоод байна.

Япон, БНСУ-ын хүн амын насжилт өндөр хурдтайгаар нэмэгдэж байгаа орнуудын тоонд багтдаг. Япон, Солонгосын засгийн газраас ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн баталгааг хангах зохицуулалт хийх үндэсний

бодлогуудыг боловсруулан гаргажээ. Япон, Өмнөд Солонгос нь хүн амын насжилт, ахмад настай иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих талаар бодлого боловсруулах, бодлогын зохицуулалт хийх тусгай хороо байгуулж, тус хороо нь хүн амын насжилтын асуудлыг хариуцсан засгийн газрын шат шатны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах үүрэгтэй ажилладаг. Үүний үр дүнд ч хүн амын насжилтын болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах талаар ихээхэн туршлага хуримтлуулсан.

Энэхүү өгүүлэлд Япон, БНСУ-ын хүн амын насжилтын өнөөгийн байдал, цаашдын хандлага, хүн амын насжилтын шалтгаан, эдгээр орнуудын хүн амын насжилт нь ахмад настны ажил эрхлэлтэнд үзүүлэх нөлөө, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах бодлого, харьцуулалтыг тусгасан болно.

2. ЯПОН, БНСУ-ЫН ХҮН АМЫН НАСЖИЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА

Одоогийн байдлаар Япон улс нь дэлхийд хүн амын насжилтаар хамгийн өндөр байгаа оронд тооцогддог. 2013 онд Японд 65 ба түүнээс дээш настай хүн амын тоо 31 саяд хүрч, нийт хүн амын 25.1 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл дөрвөн хүн тутмын нэг нь 65 ба түүнээс дээш настай хүн болжээ.³

БНСУ-ын хувьд 1970-аад оноос хойш хүн амын насжилтын үйл явц хурдасч эхэлсэн. 2013 онд 65 ба түүнээс дээш насны хүн ам 6.1 сая буюу нийт хүн амын 12.2 хувийг эзэлжээ. Япон улсын хувьд 25 жилийн дотор, харин БНСУ нь 18 жилийн хугацаанд нийт хүн амын дунд настай иргэдийн эзлэх хувь 7 хувиас 14 хувь болж 2 дахин нэмэгдсэн нь бусад орныхоос харьцангуй хурдан үзүүлэлт юм.⁴ 1970-2010 оны Япон улсын хүн амын насны бутцийг Хүснэгт 1-д үзүүллээ. 1970 онд Япон улсын хүн амд 65 ба түүнээс дээш насныхан

² <http://www.worldbank.org/mn/news/press-release/2015/12/09/policies-needed-to-tackle-labor-force-decline-higher-public-spending-in-rapidly-aging-east-asia>

³ Японы хүн амын насжилтын цагаан ном. 2013. <http://sri.kostat.go.kr>

⁴ Японы улсын нийгмийн хамгаалал ба хүн ам судлалын хүрээлэн. Хүн амын статистикийн үзүүлэлтүүд. 2013

7.07 хувийг эзэлж байсан бол 1995 онд энэ үзүүлэлт 14.56 хувь болж өсчээ. Өөрөөр хэлбэл 25 жилийн дотор 65 ба түүнээс дээш насыхны хүн амын амд эзлэх хувь нь 7.07 байснаа

14 болж, 2 дахин өссөн байна. Энэ нь урьд өмнө бусад улс оронд тохиолдож байгаагүй их хурдтай хүн амын насжилттын үйл явц болсон.

Хүснэгт 1. Япон улсын хүн амын насны бүтэц (1970-2010 он), хувиар

| Он | 0-14 нас | 15-64 нас | 65-аас дээш |
|------|----------|-----------|-------------|
| 1970 | 23.93 | 69.00 | 7.07 |
| 1975 | 24.33 | 67.75 | 7.92 |
| 1980 | 23.51 | 67.39 | 9.10 |
| 1985 | 21.51 | 68.18 | 10.30 |
| 1990 | 18.24 | 69.69 | 12.08 |
| 1995 | 15.95 | 69.49 | 14.56 |
| 2000 | 14.58 | 68.06 | 17.36 |
| 2005 | 13.76 | 66.07 | 20.16 |
| 2010 | 13.20 | 63.70 | 23.10 |

Эх үүсвэр: Японы улсын нийгмийн хамгаалал ба хүн ам судлалын хүрээлэн.

Хүн амын статистикийн үзүүлэлтүүд. 2007, 2010

Өмнө нь БНСУ-ын хүн амын төрөлтийн болон нас баралтын түвшин өндөр байсан бол 1990 оноос хойш төрөлтийн болон нас баралтын түвшин нь аажим буурч, дундаж наслалт уртассанаар хүн амын бүтцэд өөрчлөлт орсон. 1970-1980 оны хооронд БНСУ-ын нийгэм хүн амзүйн шилжилтийн нэгдүгээр үеэ түүлсан бол 1980-аад оны дунд үед хоёрдугаар үеийг дуусгаж хүн ам тогтворжих үе рүү шилжжээ. 1980-аад оноос хойш төрөлтийн түвшин буурч, 2000 оноос өнөөг хүртэл дэлхий дээрх хамгийн бага төрөлтийн түвшинтэй улс орны нэг байсаар байна. Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дагаад Өмнөд Солонгосын хүн амын нас баралтын түвшин мөн буурсан. Үүний үр дүнд Өмнөд Солонгосын нийгэмд нийт хүн ам

болон хөдөлмөрийн насны хүн ам нь хурдтай буурах асуудал тулгарсан. Энэ нь Өмнөд Солонгосын нийгэмд хүн амын насжилтанд урьдчилан бэлтгэх шаардлагатай тулгарсан.

Хүснэгт 2-с бид БНСУ-д 1990 онд 0-14 насны хүүхэд нийт хүн амын 25.6 хувийг эзэлж байсан бол 2000 онд 21 хувь, 2010 онд 16.2 хувь болж буурсныг харж болно. Харин эсрэгээр энэ хугацаанд 65 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь тасралтгүй өсчээ.

Зүүн Азид насжилт ийнхүү огцом өсөж байгаа нь нэг талаар сүүлийн арван жилийн хугацаанд тус бүсийн эдийн засаг асар хурдацтай хөгжсөнтэй холбоотой гэж Дэлхийн Банкны тайланд дурджээ.

Хүснэгт 2. БНСУ-ын хүн амын насны бүтэц (1970-2010 он), хувиар

| Он | 0-14 нас | 15-64 нас | 65-аас дээш |
|------|----------|-----------|-------------|
| 1970 | 42.5 | 54.4 | 3.1 |
| 1975 | 38.6 | 58.0 | 3.4 |
| 1980 | 34.0 | 62.2 | 3.8 |
| 1985 | 30.2 | 65.6 | 4.3 |
| 1990 | 25.6 | 69.3 | 5.1 |
| 1995 | 23.4 | 70.7 | 5.9 |
| 2000 | 21.1 | 71.7 | 7.2 |
| 2005 | 19.1 | 71.6 | 9.2 |
| 2010 | 16.2 | 72.9 | 11.0 |

Эх үүсвэр: БНСУ-ын статистикийн хороо. 2010 оны нийгмийн үзүүлэлтүүд

Өндөр орлоготой, боловсролын түвшин сайтай нөхцөлд хувь хүний насжилт уртасдаг, улмаар төрөлтийн хувь хэмжээ буурч, хүн амын нөхөн үржихүйн үзүүлэлт багатай улс орны тоо олшиирсоор байна. Мөн энэхүү тайланд 2010 онд хамгийн өндөр насжилттай 25 улс тутмын нэг нь Зүүн Азийн улс байсан бол 2060 он гэхэд дэлхийн хамгийн өндөр насжилттай таван улс тутмын нэг нь Зүүн Азийн улс байх төлөвтэй байна.

Япон нь хүн амын насжилтын түвшин маш өндөр хурдтай өсч буй, мөн насжилтын эзлэх хувь хамгийн өндөртэй орон юм. Японы улсын нийгмийн хамгаалал ба хүн ам судлалын хүрээлэнгийн судалгааны үр дүнг дараах хүснэгтээс харж болно. 2050 он болон 2100 онуудад дэлхийн хүн амын насжилтаар тэргүүлж байгаа 5 орнуудын эгнээнд Япон улс байсаар байна.

Хүснэгт 3. 65 ба түүнээс дээш насны иргэдийн эзлэх хувь өндөртэй орнууд, хувиар

| 1950 | | 2010 | | 2050 | | 2100 | |
|--------|------------|--------|------------|----------|------------|------------|------------|
| Улс | Эзлэх хувь | Улс | Эзлэх хувь | Улс | Эзлэх хувь | Улс | Эзлэх хувь |
| Франц | 11.39 | Япон | 22.39 | Тайвань | 35.69 | Коста-Рика | 32.44 |
| Латви | 11.18 | Герман | 20.38 | Япон | 35.69 | Катар | 31.95 |
| Бельги | 11.01 | Итали | 20.35 | Португал | 33.97 | Албани | 31.88 |
| Исланд | 10.97 | Грек | 18.55 | БНСУ | 32.80 | Япон | 31.60 |
| Англи | 10.83 | Швед | 18.24 | Итали | 32.70 | Тайвань | 31.48 |

Эх үүсвэр: <http://ipss.go.jp>

3. ЯПОН, БНСУ-ЫН ХҮН АМЫН НАСЖИЛТЫН ШАЛТГААН

Япон болон БНСУ-ын хүн амын насжилтанд хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хучин зүйл ихээхэн нөлөөлсөн. Богино хугацаанд төрөлтийн түвшин огцом буурсан, мөн үүний зэрэгцээ хүн амын дундаж наслалт нэмэгдсэн нь Япон болон Өмнөд Солонгосын хүн амын насжилт хурдсах хамгийн чухал хүн ам зүйн шалтгаан болсон. Япон, Өмнөд Солонгосын эдийн засгийн хурдтай өсөлт, хотжилтын түвшин хурдацтай нэмэгдсэн, боловсролын түвшин сайжирсан зэрэг нь түүний хүн амын насжилтанд нөлөөлж буй чухал нийгэм, эдийн засгийн шалтгаанууд болсон.

Эдийн засаг хурдтай хөгжсөнөөр хөдөө аж ахуйд түшиглэсэн улс орноос аж үйлдвэржсэн орон болж шилжсэн. Эдийн засгийн хөгжил нь хүн амын хоол тэжээлийн хангамж, эмнэлгийн болон эрүүл мэндийн үйлчилгээний түвшинг сайжруулж, халдварт өвчний тархалтыг бууруулах, иргэдийн боловсролын түвшинг сайжруулахад нөлөөлсөн. Эдгээр хүчин зүйлс нь дундаж наслалтыг уртасгах, нас баралтыг бууруулах гол шалтгаан болсон.

Хотжилтийн процесс нь Япон, Өмнөд Солонгосын хүн амын насжилтын үйл явцад ихээхэн нөлөө үзүүлсэн. Хөдөө

орон нутгийн иргэд олноор хотод шилжин суурьшиж, сургуулийн насны залуучуудын тоо нэмэгдсэнээр хотын хүн ам ёссан. Гэхдээ эдийн засгийн өндөр хурдтай үед хүн ам гадагшаа шилжсэн нутгийн насны бүтэц тэнцвэргүй болж, насжилтын үзэгдэл илрэх болсон.

Боловсролын түвшин нэмэгдсэнээр хүмүүсийн сэтгэлгээ, үнэт зүйлс өөрчлөгдөж, залуу хосууд амьдралын уламжлалт арга хэвшлийг өөрчилж, аажмаар хүйсээр ялгаварлан гадуурхах, жендерийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүд тэгш байдлаар ажил эрхлэхтэй холбоотой бий болсон өөрчлөлтүүд нь төрөлтийн түвшинд нөлөөлжээ.

Япон, Өмнөд Солонгосын хүн амын насжилтаас үүдэж хүн амын бүтэц өөрчлөгдөх, хөдөлмөрийн насны хүн амын хэмжээ, эзлэх хувийн жин буурах, мөн хөдөлмөрийн насны хүн ам насжиж, үүнээс шалтгаалан эдийн засгийн өсөлт удаашрах байдал үүсэх байдал илэрч байна. Хүн амын насжилтаас шалтгаалж хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин буурч, хөдөлмөрийн нийлүүлэлтэнд хомсдол үүсэх нь макро түвшинд настай иргэдийн ажил эрхлэлтэнд дэмжлэг үзүүлэх нөхцөл болдог. Хүн амын насжилтын хурд нэмэгдэх нь тухайн нийгэмд өндөр настнуудын нийгмийн халамж,

тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгалтай холбогдох маш их дарамтыг авч ирдэг. Энэ дарамтыг багасгахын тулд тэтгэвэрт гарах насыг хойшилуулах, ахмад настай хүмүүсийн ажил эрхлэлтийг дэмжсэнээр тодорхой хэмжээнд энэхүү нийгмийн ачааллыг багасгаж болно.

4. ЯПОН, БНСУ-ЫН ХҮН АМЫН НАСЖИЛТ НЬ АХМАД НАСТНЫ АЖИЛ ЭРХЛЭЛТЭНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хүн амын насжилт нь Япон, Өмнөд Солонгосын нийгэм, эдийн засагт ихээхэн нөлөө үзүүлж байна. Энэхүү нөлөөг макро түвшинд болон микро түвшинд үзүүлэх нөлөө хэмээн 2 ангилж болно. Тухайлбал, ажиллах хүчиний үр ашигтай нийлүүлэлт, хэрэглээ ба хадгаламж, үйлдвэрлэлийн бүтэц, аж ахуйн нэгжийн ажлын өртөг, аж ахуйн нэгжийн тэтгэврийн даатгалын шимтгэл, өрх гэр бүлд үзүүлэх нөлөөг дурдаж болно. Япон, БНСУ-ын хүн амын насжилт нь ахмад настны хөдөлмөр эрхлэлтэнд шууд ба шууд бусаар нөлөөлж байна.

Макро түвшинд үзүүлэх нөлөө. Хүн амын насжилтын нөлөөгөөр Япон, БНСУ-ын хүн амын бүтэц өөрчлөгдөж, хөдөлмөрийн зах зээл, капиталын зах зээл, төсөв санхүүд нөлөө үзүүлдэг. Хүн амын насжилт нь хөдөлмөрийн насны хүн амын цар хүрээ, эзлэх хувийг бууруулах төдийгүй хөдөлмөрийн насны хүн ам нь насжаснаар эдийн засгийн уналт, хүндрэлд хүргэж болно. Япон, БНСУ-ын хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь хэмжээ буурч, ажиллах хүчиний нийлүүлэлтэнд хүндрэл гарч, энэ нь ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нөхцөлд хүргэж байна.

Хадгаламжийн хувь хэмжээг бууруулах нь хүн амын насжилтын эдийн засагт үзүүлэх бас нэгэн нөлөө юм. Хүн амын насжилт нь эрэлт, нийлүүлэлтийн хоорондын тэнцвэрт байдлыг алдагдуулдаг. Төрөлтийн түвшин бага үед хүн ам насжих нь ажиллах хүчийг бууруулж, хадгаламжийн хувь хэмжээг бууруулдаг.

Настай иргэдийн тоо өсөх үед хэрэглэгчийн тоо буурдаг. Хүн амын насжилт нь нийтийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд зарцуулах зардлыг нэмэгдүүлэх болно. Хөдөлмөрийн насны хүн ам буурснаар засгийн газрын татварын орлого буурах, хадгаламж буурах, санхүүгийн хөрөнгө, хөрөнгө оруулалт

хумигдаж, эдийн засгийн өсөлт удаашрахад хүргэдэг.

Хүн амын насжилт нэмэгдсэнээр Япон, Солонгосын хүн ам зүйн ачаалал нэмэгдэж, нийгмийн ачаалал хүндэрч, нийгмийн хамгаалалд ихээхэн дарамт авч ирж байна. Энэ дарамтыг бууруулахын тулд ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, дэмжлэг үзүүлэх, тэтгэвэрт гарах насыг хойшилуулах нь тодорхой хэмжээгээр насжилтын ачааллыг багасгах болно.

Микро түвшинд үзүүлэх нөлөө. Хүн амын насжилт нь өрх гэр болон хувь хүнд шууд үзүүлэх нөлөө нь ахмад настнуудын амьдрал болон амьдралын чанарын олон янз байдал юм. Энэ нь настай иргэдийн бие махбодийн болон сэтгэл санааны эрүүл мэнд, өндөр настнуудын орлого, амьдралын хэв маяг гэх мэт талууд дээр янз бүрээр нөлөө үзүүлдэг нь засгийн газраас ахмадуудын асуудалд анхаарах зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь ихээхэн чухал ач холбогдолтой үйл хэрэг болж байна.

5. ЯПОН, БНСУ-ЫН АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ БОДЛОГО, ХАРЬЦУУЛАЛТ

Япон, БНСУ-ын хувьд өндөр настнуудыг хөдөлмөр эрхлүүлснээр хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн тэтгэврийн ачааллыг багасгах боломжтой юм.

Япон, БНСУ-ын ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах бодлогын ижил тал

1. Хүн амын насжилт, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг төрийн бодлогын түвшинд хэрэгжүүлэх

Япон улс нь төрөлт буурч буй нийгэмд хариу арга хэмжээ авах зорилготой Засгийн газрын хэрэг эрхлэх газрын харьяа комиссыг байгуулсан. Яамдын сайд нар нь энэхүү хорооны гишүүд байдаг. Харин БНСУ-д бага төрөлтийн түвшинтэй, насжиж буй нийгмийн хороог байгуулжээ. Тус хороо нь бодлого боловсруулж, шат шатны төрийн байгууллагын хүчийг нэгтгэснээр хүн амын насжилтын асуудал дээр ихээхэн шийдвэртэй алхмыг хийж байна. Япон, БНСУ-ын хувьд улс даяар хүн амын насжилт нь эдийн засаг, нийгмийн хөгжилд, ялангуяа ажиллах хүчинд шууд нөлөө үзүүлэхийг тооцож, ахмад настай ажиллах хүчин нь хүн ам насжиж буй

нийгэмд ажиллах хүчний дутагдлыг нөхөх боломжийг тооцоолж, холбогдох бодлогуудыг тодорхойлон ахмадуудыг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжиж, мөн багагүй үр дүнд хүрээд байна.

2. Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль эрх зүйн орчинг бий болгосон.

Япон улс ахмадуудын ажил эрхлэлтийг дэмжих “ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдлын тухай хууль” баталсан. БНСУ нь “хөдөлмөр эрхлэлтэнд хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглох”, “Хөдөлмөр эрхлэлтийн харьцааны стандарт” гэх мэт хуулийг баталсан. Дээрх хуулиудад бүгдэд нь ахмад настнуудыг ажлын байраар хангах аж ахуйн нэгжийн үүрэг, тавигдах шаардлагуудыг тусгасан.

3. Япон, БНСУ-ын төв засгийн газраас ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд төсвөөс ихээхэн хэмжээний санхүүжилт гаргасан.

Ахмад настны ажил эрхлэлтийн бодлогыг идэвхитэй дэмжихийн тулд:

- i. ахмад иргэдийг эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг дэмжих
- ii. ахмадуудыг ажиллуулах ажил олгогчийг идэвхитэй дэмжих
- iii. ахмадуудын ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна.

Эдгээр бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж мөнгө санхүүгийн дэмжлэгийг давхар үзүүлдэг. Япон, БНСУ-ын аль алинд хөдөлмөр эрхлэлтийг нь идэвхижүүлэхийн тулд настай иргэдэд төрөөс олгох тэтгэврээ авахын зэрэгцээ хөнгөлөлттэй цалингаар ажиллах боломжийг олгодог.

Ахмадуудадажилолгожбуйажахуяннэгжүүдэд Япон, БНСУ-ын Засгийн газраас олон төрлийн татаасыг олгож, ажлын орчинг сайжруулах, шинэ технологи тоног төхөөрөмжийг татахад дэмжлэг үзүүлэх байдлаар ахмад хүмүүсийг ажилд авч буй компаниудын ачааллыг бууруулдаг байна. Ажлын байрыг нэмэгдүүлэх тал дээр төв засгийн газар нь иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ахмад настанд тохирох ажлын байрыг нэмэгдүүлж, ахмад настнуудын орлогыг ёсгэх боломжоор хангахын зэрэгцээ ахмад ажиллах

хүчний нөөцийг бүрэн ашиглахаар ажиллаж байна.

4. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд тэтгэврийн насыг уртасгаж, тэтгэврийн бодлогод зохицуулалт хийсэн.

Япон нь ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг аажмаар тэтгэврийн насыг уртасгах, тэтгэврийн мөнгө авч эхлэх насыг зохицуулахад илүү чиглүүлсэн. Японы хүн амын насжилт 7 хувийг давснаар буюу 1970-аад оноос тэтгэврийн насыг хойшлуулах талаар Японы Засгийн газраас санал болгож, компаниуд хүлээн авч, хэрэгжүүлснээр хуульд өөрчлөлт оруулж тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлсэн. Тэтгэвэр, нийгмийн халамжийн тогтолцоонд шинэчлэл хийж тэтгэврийн насыг 60-аас 65 нас болгон сунгасан. БНСУ-ын хувьд ч мөн компаниудын зөвшөөрөлтэйгээр тэтгэврийн нас 60 хүрэхгүй байсныг 60 болгосон байна. Мөн БНСУ-ын Засгийн газар жил бүр ажилтнуудын тэтгэвэрт гарах настай холбогдох тайланг компаниудаас гаргаж өгөхийг шаарддаг бөгөөд засгийн газрын тогтоол, журмыг биелүүлээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцдог байна. Үүний зэрэгцээ, БНСУ-ын Засгийн газар тэтгэвэрт гарах насыг хойшлуулах, ахмад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэтгэвэрт гарахаа хойшлуулсан ахмад настай иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгосон.

5. Ахмадуудын мэргэжлийн сургалт, насан туршийн боловсролд анхаарах

Японд ахмад настнуудын мэргэжлийн сургалтын оролцооны түвшин нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын орнуудын дотор харьцангуй өндөр, залуучуудын мэргэжлийн сургалтын түвшинтэй харьцуулахад бага зөрүүтэй байдаг. Япон нь олон нийтийн ажил эрхлэлтийн тогтвортой байдлыг хангах төв, мэргэжлийн сургалтын төвөөр дамжуулан дунд болон ахмад настангуудад мэргэжлийн сургалтанд хамрагдах, ажлын байртай болох боломжийг хангаж өгдөг байна.

6. Хүн амын насжилт, ахмад настнуудын ажил эрхлэлттэй холбогдох судалгааны ажилд ихээхэн анхаарч байна.

Засгийн газрын яам, агентлагууд болон судалгааны байгууллагууд нь холбогдох судалгааны ажлуудыг гүйцэтгэж, тайлан

гаргадаг. Жишээ нь, Япон жил бүр “Хүн амын насжилтын цагаан ном”, “Насжилт явагдаж буй нийгэмд хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Хөдөлмөр эрхлэлтийн цагаан ном”, “Хөдөлмөрийн эдийн засгийн шинжилгээ” гэх мэт тайлангуудыг эрхлэн гаргадаг. БНСУ-д жил бүр “Ахмад настнуудын амьдралын нөхцөл байдлын судалгааны тайлан”, “БНСУ-ын ахмад настнуудын ажлын байрны хэрэгжилтийн тайлан” гэх мэт тайланг хэвлэн гаргадаг. Тайлангийн агуулга нь маш нарийвчилсан, ахмадуудын ажлын байртай холбогдох бүхий л асуудлыг хамардаг. Засгийн газрын зүгээс эдгээр тайлангуудын мэдээлэл дээр үндэслэн цаг тухайд нь бодлогуудад зохицуулалт хийж, ахмад настнуудын дахин ажил эрхлэх талаарх бодлогуудыг сайжруулдаг байна.

Япон, БНСУ-ын ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах бодлогын ялгаа

1. Хүн амын насжилт явагдсанаар тэтгэврийн насыг тогтоож, өөрчилж буй цар хүрээ, хэмжээгээр ялгаатай.

Япон нь тэтгэвэрт гарах насыг өөрчлөх талаар удаан хугацаанд бэлдсэн. 2013 оноос эхлэн тэтгэврийн насыг 65 болгосноор хууль ёсны дагуу 65 нас хүртэл ажиллахаар болсон. Япон нь тэтгэвэрт гарах насыг сунгахын зэрэгцээ цааш үргэлжлүүлэн ажиллах тогтолцоог тэтгэвэр авахын зэрэгцээ ажил эрхлэхтэй холбогдожүүсч болохасуудлуудаасзайлсхий, тэтгэврийн мөнгө авахгүй, орлогогүй ахмад настнуудын бүлэг үүсэх нөхцөлийг арилгах асуудалтай амжилттай холбож чадсан.

БНСУ-д нийгмийн хамгаалал, тэтгэврийн тогтолцоо арай хожуу үүссэн тул цаашид ч сайжруулах шаардлага байсаар байна. БНСУ нь ажилтанг насан туршид нь ажиллуулах тогтолцоотой улс биш учраас аж ахуйн нэгжийн дотоод дахь ажиллах хүчийг халах, өөрчлөх томоохон өөрчлөлтийн үед хугацаанаасаа өмнө тэтгэвэрт гарах тохиолдол байсаар байна. Тэтгэвэр авах нас хүрээгүй байхад тэтгэвэрт гаргах асуудлыг зохицуулаагүй тул тэтгэврийн мөнгөгүй, орлогогүй байх нөхцөл бүрэлддэг. Энэхүү тогтолцоо нь мөн л олон талаар БНСУ-ын ахмад настай иргэдийг дахин ажил эрхлэхэд хүргэдэг.

2. Ахмад настнуудын ажил эрхлэлтийг дэмжих бодлогын гол чиглэлүүд ялгаатай.

Япон улсад төв болон орон нутгийн нийтийн ажил эрхлэлтийг тогтвржуулах төвүүдээр

дамжуулж ахмадуудад ажил эрхлэлтий холбоотой мэдээ, танилцуулгыг өгч байна. Харин Солонгос ахмадуудын клуб, ахмадуудын нийгмийн халамжийн төвүүдээр дамжуулж ажил эрхлэх зар, мэдээллийг ахмадуудад түгээдэг байна. Япон болон БНСУ нь ахмадуудад идэвхитэй ажил олгож буй аж ахуйн нэгжүүдийг урамшуулж, холбогдох татаасуудыг олгодог. БНСУ-ын ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын цөм нь ахмад настнуудын ажлын байрыг нэмэгдүүлэхэд анхаардаг. Иймд “Хөдөлмөр эрхлэхэд насаар ялгаварлан гадуурхахыг хориглох”, “ажил олголтын түвшингийн лавлагaa”, “ахмад настаны ажлын байрыг үүсгэх” талаарх бодлогуудыг боловсруулсан. Харин Япон улс ажилчдын тэтгэвэрт гарах насыг хойшлуулах, 65 нас хүртлээ ажиллах бодлогыг түлхүү анхаардаг.

3. Ахмад настнуудад ажил олгохыг дэмжих татаасыг олгох хэлбэрээр ялгаатай.

Япон болон БНСУ-д төв засгийн газраас ахмадуудад ажил олгосон аж ахуйн нэгжид тодорхой хэмжээний татаас олгодог. Боловсрол, сургалтын төлбөрийг Японд ахмад настнуудад өөрт нь олгодог бол Өмнөд Солонгост шууд сургалт явуулж буй байгууллагуудад өгдөг байна. Цалинг бууруулсаныг нөхөх татаасыг Японд ахмадуудад өгдөг бол, БНСУ-д байгууллагад нь олгодог. Японы хувьд ахмадуудын тэтгэврийг бууруулсан хэмжээ, цалинг бууруулсан хэмжээ болон үнийн өсөлт гэх мэт хүчин зүйлсийг бүхэлд нь харгалзан татаас олгодог байна.

4. Ахмад настан ажил эрхлэх талаарх нийгэм, соёл, уламжлалт үзлээр ялгаатай.

Солонгос нь ахмадуудаа хүндэтгэдэг уламжлалтай учраас энэ нь ажил олгогчдын хувьд болгоомжлол үүсгэхэд хүргэдэг. Мөн үр хүүхэд нь эцэг эхийгээ асрах уламжлалтай тул ажил эрхлэх нь хүүхдүүдэд нь сөрөг нөлөө авч ирэх байх гэх мэт хүчин зүйл ажил эрхлэх идэвхид нөлөөлдөг.

Японд барууны соёлын нөлөөгөөр ахмадууд ажиллах уур амьсгалыг бүрдүүлж, аж ахуйн нэгж, хувь хүн, айл өрх бүгд ахмад настнуудын ажил эрхлэлтийг хүлээн зөвшөөрөх болжээ.

6. ДҮГНЭЛТ

Одоогийн байдлаар Япон улс нь дэлхийд хүн амын насжилтаар хамгийн өндөр байгаа оронд тооцогддог. Япон улсын хувьд 25 жилийн дотор, харин БНСУ нь 18 жилийн хугацаанд нийт хүн амын дунд ахмад настай иргэдийн зэлэх хувь 7 хувиас 14 хувь болж 2 дахин нэмэгдсэн нь бусад орныхоос харьцангуй хурдан үзүүлэлт юм.⁵

Японы улсын нийгмийн хамгаалал ба хүн ам судлалын хүрээлэнгийн судалгаагаар 2050 он болон 2100 онуудад дэлхийн хүн амын насжилтаар тэргүүлж байгаа 5 орнуудын эгнээнд Япон улс байсаар байхыг тодорхойлжээ. Мөн Дэлхий банкнаас гаргасан тайланд 2040 он гэхэд насжиж байгаа хүн амын өсөлтийн улмаас БНСУ-д хөдөлмөрийн насны хүн амын тоо 15 хувь, Хятад, Тайланд, Японд 10 хувь буурах магадлалтай байна. Хятад Улс дангаараа 90 сая ажилтнаа цэвэр алдана гэсэн байна.

Хүн амын насжилтын хурд нэмэгдэх нь тухайн нийгэмд өндөр настнуудын нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгалтай холбогдох маш их дарамтыг авч ирдэг. Энэ дарамтыг багасгахын тулд тэтгэвэрт гарах насыг хойшлуулах, ахмад настай хүмүүсийн ажил эрхлэлтийг дэмжсэнээр тодорхой хэмжээнд энэхүү нийгмийн ачааллыг багасгах бодлогыг эдгээр орнууд амжилттай хэрэгжүүлж байна.

Дээрх орнууд ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль эрх зүйн орчинг сайжруулах, төсвөөс ихээхэн хэмжээний санхүүжилт, татаас олгох, тэтгэврийн насыг уртасгаж, тэтгэврийн бодлогод зохицуулалт хийхийн зэрэгцээ ахмадуудын мэргэжлийн сургалт, насан туршийн боловсролд анхаарч байна. Мөн өөрсдийн нийгэм, эдийн засгийн хөгжилд тохирох ахмад настнуудын ажил эрхлэлтийн бодлогыг боловсруулахдаа энэ талаарх судалгаа, эрдэм шинжилгээний ажил, тайланд ихээхэн ач холбогдол өгч байна. Нийгэм нь бүхэлдээ ахмадуудыг ажиллах уур амьсгалыг бүрдүүлж, аж ахуйн нэгж, хувь хүн, айл өрхүүд ахмад настнуудын ажил эрхлэлтийг хүлээн зөвшөөрөх болсон.

Япон, БНСУ-ын засгийн газраас хүн амын насжилт, ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтэнд ихээхэн ач холбогдол өгч, төрийн

⁵ Японы улсын нийгмийн хамгаалал ба хүн ам судлалын хүрээлэн. Хүн амын статистикийн үзүүлэлтүүд. 2013

бодлогоор дэмжин зохицуулж, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг засгийн газрын хөтөлбөр болгон хэрэгжүүлснээр ахмад хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн тэтгэврийн дарамтыг бууруулж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах ажиллах хүчний нөөцийг бий болгож чаджээ.

Хэдийгээр Монгол улс хүн ам насжилтын асуудалтай тулгараагүй байгаа ч Зүүн Азийн хүн ам өндөр насжилттай улс орнуудын туршлагаас суралцах, бэлтгэх нь чухал юм.

Ашигласан материал:

Японы улсын нийгмийн хамгаалал ба хүн ам судлалын хүрээлэн. Хүн амын статистикийн үзүүлэлтүүд. 2007, 2010, 2013

Японы хүн амын НАСЖИЛТЫН цагаан ном. 2013.

БНСУ-ын статистикийн хороо. 2010 оны нийгмийн үзүүлэлтүүд

UN(2010),World Population Prospects:The 2010 Revision

Li Mei Hua. The Study of Population Aging and Senior Citizen Employment Policies in Japan and South Korea.2014

青木玲子.A Demographic Perspective on Japan's Lost Decades. Population and Development Review 38(supplement):103-112, 2013

<http://www.worldbank.org/mn/news/press-release/2015/12/09/policies-needed-to-tackle-labor-force-decline-higher-public-spending-in-rapidly-aging-east-asia>

<http://sri.kostat.go.kr>

<http://ipss.go.jp>

<http://esa.un.org/>

<http://www.kosis.co.kr>